



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/387

Булган сум

Гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 2024 оны 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолын хавсралтын 1.4.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дэлхийн “Алтаргана 2024” XV Олон улсын их наадам зохион байгуулахад хэрэглэгдэх Булган сумын Соёлын ордны үзэгчдийн 250 ширхэг сандал нийлүүлэх компаниар “Тансаг төгөл” ХХК-ийг сонгож 16,000,000 (арван зургаан сая) төгрөгөөр шууд гэрээ байгуулах эрхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д олгосугай.

2. Гэрээнд заасан барааг чанарын өндөр түвшинд нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Тансаг төгөл” ХХК-ны захирал (Д.Мягмарсүрэн)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4. Сандалын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010493